

Үндэсний хөгжлийн газрын даргын
2019 оны 10 сарын 14-ны өдрийн
А-188... дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖИЛ” БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

2019 оны 10-р сарын 14-ны өдөр

№...

Улаанбаатар хот

Зорилго	Энэхүү судалгааны зорилго нь Монгол хүний эрүүл саруул, урт удаан наслах, сурч боловсрон, эрдэм мэдлэг эзэмших, тохиромжтой хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх, бие хүн болон төлөвших зэргийг эхийн хэвлийд бүрэлдсэн ургийн үеэс нь эхлэн физиологийн болон оюун ухааны хөгжилтэй уялдуулан, амьдралын мөчлөг бүрд нь тохирсон хөгжлийн бодлого боловсруулах суурь судалгаа хийж гүйцэтгэхэд оршино.
Үндэслэл	Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 5.2.9 дэх заалт;
Хугацаа	<ol style="list-style-type: none">1. Захиалагч болон Зөвлөхийн хооронд гэрээ байгуулсанаас хойш гүйцэтгэгч ажлын даалгаврыг 30 хоногийн дотор гүйцэтгэх бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.2. Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсанаар ажил эхэлж, захиалагч тал эцсийн тайланг хүлээн авсанаар дуусгавар болно.
Ажлын хамрах хүрээ	<p>Зөвлөх үйлчилгээний баг нь захиалагчтай байнга харилцаж, бүх талын мэдээллээр ханган ажиллах бөгөөд гэрээний хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. Судалгааны ажлуудыг гүйцэтгэх тоон болон чанарын шинжилгээ, нийлмэл шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй, аргачлалыг нарийвчлан боловсруулж Захиалагчид танилцуулах;2. Хууль, эрх зүй, бодлогын орчны судалгаа хийх;3. Дотоод нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх /хүний хөгжлийн индекс, боловсролын тогтолцоо, эрүүл мэндийн тогтолцоо, хоол тэжээлийн чанар, хангамж, ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр нийгмийн хамгааллын тогтолцоо, амьжиргааны зохистой нөхцөл, хүний эрх, эрх чөлөө, жөндөр, шашин шүтлэг, хүмүүжил олгох хэлбэрүүд, уламжлал, зан заншил, ген, антропологи гэх мэт/;4. Хөрш орнууд болон байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд ижил төстэй гадаад орны туршлагаас харьцуулан судлах /ОХУ, БНХАУ, Казахстан, БНСУ, Япон/;5. Хүний хөгжлийг хэмжих ОУ-ын индекс, түүнийг тооцох аргачлал, Монгол хүний хөгжлийг хэмжиж буй аргачлал, түүний бодит нийцлийг судлан, дүгнэлт хийх;6. Хүний хөгжилтэй холбоотой ОУ-ын стандартууд, мөрдөгдөж буй дэвшилтэт арга /амьдрах, амрах, ажиллах, боловсрох, хөгжих орчин болоод хүнс тэжээлийн талаарх төсөөлөл, хоолзүй, орон байр, ерхийн

	<p>орлого, эрүүл мэндийн стандартууд гэх мэтийг сонгон шигтгэж болно/;</p> <p>7. Нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох;</p> <p>8. Дунд хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;</p> <p>9. Монгол хүнийг хөгжүүлэх урт хугацааны бодлогын зөвлөмж боловсруулах;</p> <p>10. Судалгааны ажлын тодотгосон, нэгдсэн, дэлгэрэнгүй график гарган Захиалагчид танилцуулах; /Мэдээлэл, дата, мэдлэгийг цогц байдлаар түргэн, тодорхой, нэг дор өгөх бүтээмж бүхий график дүрслэлт илэрхийлэл буюу Инфографик хийх/</p> <p>Дээр дурдсан хамрах хүрээний дагуу ажлын график төлөвлөгөө гарган Захиалагч талд танилцуулан, зөвшилцөн баталгаажуулсны үндсэн дээр ажил үйлчилгээг явуулна</p>
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багт дараах шаардлагууд тавигдана. Үүнд:</p> <p>A. Зөвлөх үйлчилгээний туршлагатай, хуулийн этгээд байх;</p> <p>B. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлдөг байх;</p> <p>C. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчөөгүй байх;</p> <p>D. Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолгүй байх;</p> <p>E. Таван голлох мэргэжилтнээс бүрдсэн Зөвлөх багтай байх;</p> <p>Голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:</p> <p>A. Боловсрол, нийгмийн ухааны салбарын зөвлөх - Багийн ахлагч</p> <ul style="list-style-type: none"> - Боловсролын удирдлага, боловсролын салбарын хөгжлийн бодлого төлөвлөлт, иргэний боловсрол, монгол хүний бие бялдрын хөгжил, монгол хүний ген, зан заншил, амьдралын онцлог орчин нөхцөл, үндэсний өв соёл, боловсрол судлалын чиглэлээр мэргэшсэн, Боловсролын удирдлага, Багш, Философич, Нийгэм судлаач, Сэтгэл зүйч, Түүхч, Шашин судлаач, Угсаатны зүйч, Антропологич, Соёл судлаач, Монгол судлаач мэргэжилтэй байх; - Доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх; - Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх; - Удирдах ажлын 3-с доошгүй жилийн туршлагатай; - Судалгаа шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай байх; - Гадаад, дотоодын компаниудад зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байсан туршлагатай; - Ажлыг богино хугацаанд зохион байгуулах, даалгаврыг биелүүлэх, ачаалал даан ажиллах чадвартай; - Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай, зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай; - Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны гадаад хэлний мэдлэгтэй байх; - Судлахаар өгөгдсөн улсуудаас аль 1 улсын хэлийг эзэмшсэн байвал давуу тал болно.

Б. Эдийн засаг, бизнесийн удирдлагын салбарын зөвлөх - 1

- Эдийн засгийн салбар хоорондын уялдаа холбоо, микро, макро түвшний үзүүлэлтүүдэд тоон болон чанарын судалгаа, шинжилгээ хийж, харилцан хамаарлыг тодорхойлох чиглэлээр мэргэшсэн, Эдийн засагч, Эдийн засгийн математик загварчлал, Бизнесийн удирдлагын мэргэжилтэй байх;
- Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх;
- Судалгаа шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай байх;
- Гадаад, дотоодын компаниудад зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байсан туршлагатай;
- Ажлыг богино хугацаанд зохион байгуулах, даалгаврыг биелүүлэх, ачаалал даан ажиллах чадвартай;
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай, зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай;
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны гадаад хэлний мэдлэгтэй байх;
- Судлахаар өгөгдсөн улсуудаас аль 1 улсын хэлийг эзэмшсэн байвал давуу тал болно.

В.Хууль, эрх зүйн салбарын зөвлөх - 1

- Хүний эрх, Олон улсын нийтийн эрх зүй, Эдийн засгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, Эрх зүйч мэргэжилтэй байх;
- Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
- Судалгаа шинжилгээний болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын туршлагатай байх;
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай, зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай;
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны гадаад хэлний мэдлэгтэй байх;
- Судлахаар өгөгдсөн улсуудаас аль 1 улсын хэлийг эзэмшсэн байвал давуу тал болно.

Г. Эрүүл мэнд, хоол зүй, шим судлалын салбарын зөвлөх - 1

- Эрүүл хүнс, хоол зүй, шим тэжээл, эрүүл хооллолт, статистик дүн шинжилгээ, судалгааны чиглэлээр мэргэшсэн, Эмчилгээний хоол зүй, Хоол эмчилгээний эмч, Хоол зүйч, Хүнсний технологи, Шим тэжээл судлаач мэргэжилтэй байх;
- Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
- Судалгаа шинжилгээний болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын туршлагатай байх;
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай, зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай;
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг

	<p>судлах англи хэлний мэдлэгтэй байх; - Судлахаар өгөгдсөн улсуудаас аль 1 улсын хэлийг эзэмшсэн байвал давуу тал болно.</p> <p>Д. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зөвлөх - 1 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай, нийгмийн хамгаалал, жендер, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал чиглэлээр мэргэшсэн, хөдөлмөрийн эдийн засагч, нийгмийн ажил, сэтгэл судлал, социологич мэргэжилтэй байх; - Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх; - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх; - Судалгаа шинжилгээний болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын туршлагатай байх; - Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай, зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай; - Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах англи хэлний мэдлэгтэй байх; - Судлахаар өгөгдсөн улсуудаас аль 1 улсын хэлийг эзэмшсэн байвал давуу тал болно.</p>
Тайлангийн хуваарь	<ol style="list-style-type: none"> 1. <u>Эхлэлийн тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор Захиалагчид хүргүүлнэ. 2. <u>Эцсийн тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор Захиалагчид хүлээлгэн өгч, Захиалагч дахин санал, зөвлөмжгүй бол хүлээн авч, баталгаажуулснаар ажил дуусгавар болно. <p>Долоо хоног бүр ажлын явц, нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар захиалагчид танилцуулж байна.</p>